

МОНГОЛ ХЭЛ

2007

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “Урам” гэсэн үгийн “а” авианд үл тохирох шинжийг ол.
А. Балархай В. Уруулын биш С. Эр чанга
D. Уйтан E. Хэлний хойгуур
2. “Ямаа” гэсэн үгэнд хэдэн авиа, хэдэн үсэг байна вэ?
А. 4 авиа, 5 үсэг В. 4 авиа, 4 үсэг С. 5 авиа, 4 үсэг
D. 4 авиа, 3 үсэг E. 3 авиа, 4 үсэг
3. Алдаатай бичсэн үгийг ол.
А. Судлалын В. Хөдлөлийн С. Ачлалын
D. Аялалын E. Эдлэлийн
4. Дараах үүсмэл үгсийн бүтэц, утгыг ажиглаад, бусдаасаа ялгаатай үгийг ол.
А. Санал В. Бодол С. Гэрэл
D. Гарал E. Хурал
5. Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
А. Арал В. Хэвлэл С. Гарал D. Захирал E. Энэрэл
6. Зөв бичсэн үгийг ол.
А. Явчихаарай В. Харчихаад С. Хэлчихээрэй
D. Олчихоод E. Бодчихоорой
7. Зэрэгцүүлэн холбохын “-ж” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
А. Цохь В. Тавь С. Ярь D. Халь E. Хорь
8. “Дахан доор эр, даахин доор хүлэг” гэсэн хэлцтэй ойролцоо утгатай хэлцийг ол.
А. Дархан хүн, бурхан ухаантай В. Эрхийг сурахаар, бэрхийг сур
С. Учрыг нь олж, хужрыг нь тунгаах D. Эрийг бүү бас, далайг бүү янд
E. Хайр нь гаднаа, хал нь дотроо
9. Дараах үгсийг уншаад, цэгийн оронд тохирох үгийг ол.
бамбар, хурга, дудран, ялман.....
А. Үхэр В. Гөлчгий С. Зараа D. Янгир E. Хэрэм
10. Дараах холбоо үгсийг уншаад, “ам” гэсэн үг шууд утгаараа орсон хэсгийг ол.
А. Ам гарах В. Амаа барих С. Амны хөндий
D. Ам тостох E. Амны зугаа гаргах
11. “Нүд ирмэх зуур” гэсэн хэлцтэй эсрэг утгатай үг аль нь вэ?
А. Давхих В. Удаан С. Хооронд D. Хөөрөх E. Жаргах
12. Эсрэг утгатай үг орсон хэлцийг ол.
А. Гаднаа гяланцаг, дотроо паланцаг
В. Нэг үхрийн эвэр доргивол, мянган үхрийн эвэр доргино
С. Буруу замаар будаа тээвэл, буцах замдаа шороо тээнэ
D. Үнэнээр явбал, үхэр тэргээр туулай гүйцнэ
E. Эзэн хичээвэл, заяа хичээнэ
13. Дараах үгсийг уншаад, харь үгийг ол.
А. Салхи В. Жижүүр С. Эмээл D. Алтан E. Уурга
14. Дараах үгсийг уншаад, нутгийн аялгууны үгийг ол.
А. Чөдөр В. Ширээ С. Зон D. Живаа E. Гахай

Уншиж ойлгоод задлал хийх эх

Бороотой өдөр

Нар үүлний цаана сүүдийж, намираа бороо зүсэрсэн өдөр нэг л зутруу. Нисэж яваа шувууны далавч ч хүнд, нэлэнхүй орчин дүнсийн, сэтгэлд хүнд. Нартайд сүүл огсойн оодогнох бяруу тугалын хөдөлгөөн ч удаан, наадмаар унахад хэний ч морины тоосонд ордоггүй хонгор үрээний хөл ч хүнд болсон мэт. Уулсын цаана үүл хөшгөрнө. Усны тохойд манан суунаглана. Амьтан хүний дуу чимээ ч аниргүй. Адуу мал л бие биеэ нөмөрдөн хошуурна.

Бороотой өдөр өө... гэж бухимдсан мэт зүүдгэр сэтгэлд нэг л хүнд авч ханатлаа уйлсны дараа дотор онгойх шиг тэнгэрийн хаяа нь цэлийн ирэхүй зүрх хөнгөрөх билээ. Гэвч өдөр бүр бороо ордоггүй шүү дээ! Бороотой өдөр л сэтгэл хүнд. Тиймээс ч бороотой өдөр цөөн байдаг нь яамай...
Н.Өлзийбат

15. Эхийн сэдвийг ол.
 А. Хүн, байгалийн хүн холбооны тухай
 В. Байгалийн гоо сайхны тухай
 С. Байгалийн улирлын тухай
 D. Монгол орны хөдөө нутгийн тухай
 E. Намираа борооны тухай
16. Эхийн гол санааг агуулсан хэсэг аль нь вэ?
 А. ...өдөр нэг л зутруу
 В. ...зүрх хөнгөрөх билээ
 С. ...тиймээс ч бороотой өдөр цөөн байдаг нь яамай
 D. ...адуу мал бие биеэ нөмөрдөн хошуурна
 E. ...хонгор үрээний хөл ч хүнд болсон мэт
17. Эхийн хэв маягийг тодорхойл.
 А. Хүүрнэмж
 В. Тайлбарламж
 С. Тоочимж
 D. Эргэцүүлэмж
 E. Онъсоголомж
18. Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
 А. Сонин нийтлэлийн найруулга
 В. Эрдэм шинжилгээний найруулга
 С. Албан бичгийн найруулга
 D. Уран зохиолын найруулга
 E. Ярианы найруулга
19. Эхийн гол санаанд тохирох хэлцийг ол.
 А. Ирсэн гийчин буцдаг, орсон бороо арилдаг
 В. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх
 С. Хувьтай хүн хур борооноор
 D. Дуслыг хураавал далай, дуулсныг хураавал эрдэм
 E. Үг сөрвөл хэрүүл, үүл сөрвөл бороо
20. Дээрх эхэд тодотгол гишүүн өгүүлбэр хэд байна вэ?
 А. 1
 В. 4
 С. 2
 D. 3
 E. 5
21. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн бэ?
 А. "... хонгор үрээний хөл ч хүнд болсон мэт, ... нөмөрдөн хошуурна, ... хөнгөрөх билээ, ... цөөн байдаг нь яамай" гэсэн 4 цогцолбор
 В. "... нөмөрдөн хошуурна, ... цөөн байдаг нь яамай" гэсэн 2 цогцолбор
 С. "... хонгор үрээний хөл ч хүнд болсон мэт, ... нөмөрдөн хошуурна, ... цөөн байдаг нь яамай" гэсэн 3 цогцолбор
 D. Эх бүхэлдээ 1 цогцолбор
 E. "... нэг л зутруу, ... хөл ч хүнд, ... нөмөрдөн хошуурна, ... хөнгөрөх билээ, ... цөөн байдаг нь яамай" гэсэн 5 цогцолбор
22. Дээрх эхэд орсон "оодогнох" гэсэн үгийг зөв задалсан хэсгийг ол.
 А. Оодогно + х
 В. Оодог + но + х
 С. Оодон + но + х
 D. Оо + дог + нох
 E. Оод + огно + х
23. Дээрх эхэд ороогүй үгсийн аймгийн үгийг ол.
 А. Төлөөний нэр
 В. Орон цагийн нэр
 С. Холбох үг
 D. Чимэх үг
 E. Бүгд орсон
24. Бүгд зэрэгцсэн нийлмэл үг /хоршсон нийлмэл үг/ орсон хэсгийг ол.
 А. Намираа бороо, бяруу тугал, дуу чимээ, хонгор үрээ
 В. Намираа бороо, хонгор үрээ, усны тохой, бороотой өдөр
 С. Бяруу тугал, амьтан хүн, дуу чимээ, адуу мал
 D. Намираа бороо, бяруу тугал, дуу чимээ, бороотой өдөр
 E. Бяруу тугал, амьтан хүн, дуу чимээ, хонгор үрээ
25. "Бороотой өдөр л сэтгэл хүнд" гэсэн өгүүлбэрт онцлон зурсан үг ямар гишүүн болох вэ?
 А. Өгүүлэгдэхүүн
 В. Өгүүлэхүүн
 С. Тодотгол
 D. Байц
 E. Тусагдахуун
26. "Гэвч өдөр бүр бороо ордоггүй шүү дээ" гэсэн өгүүлбэр хэлэх зорилго, аялгаараа ямар өгүүлбэр вэ?
 А. Асуух өгүүлбэр
 В. Анхааруулах өгүүлбэр
 С. Захирах өгүүлбэр
 D. Хүүрнэх өгүүлбэр
 E. Батлах өгүүлбэр
27. "... ханатлаа уйлсны дараа дотор онгойх шиг тэнгэрийн хаяа нь цэлийн ирэхүй" гэхэд ямар дүрслэх ур маяг /хэрэглүүр/ ашигласан байна вэ?
 А. Адилтгал
 В. Зүйрлэл
 С. Ихэсгэл
 D. Төлөөлөл
 E. Тойруулал
28. "Уулсын цаана үүл хөшгөрнө. Усны тохойд манан суунаглана" гэсэн хэлний нэгжүүд утгын ямар харьцаанд байна вэ?
 А. Ойролцоо утгын
 В. Эсрэг утгын
 С. Төсөө утгын
 D. Зүйлчилсэн утгын
 E. Өвөрмөц хэлцийн

3. Алдаатай бичсэн үгийг ол.
А. Малла В. Тосло С. Төлөвлө Д. Сумла Е. Нэрлэ
4. Дараах үүсмэл үгсийн бүтэц, утгыг ажиглаад, бусдаасаа ялгаатай үгийг ол.
А. Эмч В. Галч С. Тогооч Д. Сэтгүүлч Е. Хайч
5. Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
А. Онол В. Гэрэл С. Гутал Д. Сүрэл Е. Эрэл
6. Зөв бичсэн үгийг ол.
А. Гаргъя В. Бодоё С. Суръя Д. Хэлэе Е. Харая
7. Зэрэгцүүлэн холбохын “-ж” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
А. сорь В. Гунь С. Уль Д. Захь Е. Хунь
8. “Аавын бийд хүнтэй танилц, агтны бийд газар үз” гэсэн хэлцтэй ойролцоо утгатай хэлцийг ол.
А. Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа В. Хошуу нэмэхээр, хуруу нэм
С. Их санасан газар, есөн шөнө хоосон Д. Дэрээ элээхээр, дэвсээ элээ
Е. Аавын хүү адилгүй, арван хуруу тэгшгүй
9. Дараах үгсийг уншаад, цэгийн оронд тохирох үгийг ол.
Цогих, сайварлах, хатирах, шогших.....
А. Ергөх В. Гүйх С. Жонжих Д. Тэших Е. Харайлгах
10. Дараах холбоо үгсийг уншаад, “нүд” гэсэн үг шууд утгаараа орсон хэсгийг ол.
А. Нүд булаах В. Нүдний гэм С. Нүд муудах
Д. Нүд хужирлах Е. Нүдний хор гаргах
11. “Магнай тэнийх” гэсэн хэлцтэй эсрэг утгатай үг аль нь вэ?
А. Санаашрах В. Гуйх С. Итгэх
Д. Санах Е. Гомдох
12. Ойролцоо утгатай үг орсон хэлцийг ол.
А. Бушуу туулай борвиндоо баастай В. Их нохой хуцахад, бага нохой дуурайдаг
С. Дээсний ахар нь, үгийн богино нь дээр Д. Хоёр идэхгүй, хоосон хонохгүй
Е. Өдрийн бодол, шөнийн зүүд
13. Дараах үгсийг уншаад, харь үгийг ол.
А. Саван В. Жаргал С. Туулай Д. Бөөрөнхий Е. Сэлэнгэ
14. Дараах үгсийг уншаад, нутгийн аялгууны үгийг ол.
А. Байшин В. Мөндөл С. Тэрэм Д. Цамц Е. Ерөөл

Уншиж ойлгоод задлал хийх эх**Ижийгээ гомдоож болохгүй**

Хэрэг төвөгт орооцолдсон шөнө миний нойр хулжиж, орондоо хөрвөөж, өөрийн хийсэн алдаагаа бодож хэвтгэл, ижий минь мэгшин уйлах сонстов. Санд мэнд босож очвол надаас нууж уйлсан ижий минь нулимс нүдийг нь бөлцийлгөж, хацрыг нь норгожээ.

Үүнийг үзээд миний элэг эмтрэх шиг, зүрх зүсэгдэх шиг болов. Үр миний төлөө ээжийн минь өр зүрх, сэтгэл надаас илүү шаналж, надаас илүү зовж байдгийг мэдсэн юм.

Намайг шагнуулж магтаал хүлээхэд надаас илүү баярлан гялайдаг, намайг шийтгүүлж ял хүлээхэд надаас илүү шаналан зовдог хүн бол ээж минь л юм.

Ээж ээ, хүү чинь таныгаа баярлуулахаас илүү гомдоосон, хайрлахаасаа илүү зовоосон нь олон билээ. Та хүүгийнхээ төлөө хэчнээн өдөр шаналж, хэчнээн шөнө нойргүйтэж, нойтон нулимсаар дэрээ норгоо бол оо...

Гэвч хүү нь эхийнхээ сэтгэлийг мэдэрсэн нь аз, хожуу ч гэсэн ухаарсан нь зол. (Д.Баттогтох)

15. Эхийн сэдвийг ол.
А. Хүү нь хэрэг төвөгт орооцолдсон тухай В. Эхийн сэтгэлийн тухай
С. Хүүгийн шагнал, магтаалын тухай Д. Хүүгийн нойр хулжсан тухай
Е. Эхийн нулимсны тухай
16. Эхийн гол санааг агуулсан хэсэг аль нь вэ?
А. ...хацрыг нь норгожээ В. ...мэдсэн юм С. ...ээж минь л юм
Д. ...норгоо бол оо Е. ...ухаарсан нь зол
17. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтэж байна вэ?
А. “...хацрыг нь норгожээ, ...зовж байдгийг мэдсэн юм, ...ээж минь л юм, ...норгоо бол оо, ... ухаарсан нь зол” гэсэн 5 цогцолбор
В. “...хацрыг нь норгожээ, ...ээж минь нь л юм, ...норгоо бол оо, ...ухаарсан нь зол” гэсэн 4 цогцолбор

- С. "...хацрыг нь норгожээ, ...норгоо бол оо, ...зовж байдгийг мэдсэн юм, ...ухаарсан нь зол" гэсэн 4 цогцолбор
 Д. "...хацрыг нь норгожээ, ...норгоо бол оо, ...ухаарсан нь зол" гэсэн 3 цогцолбор
 Е. "...хацрыг нь норгожээ, ...зовж байдгийг мэдсэн юм, ...норгоо бол оо, ...ухаарсан нь зол" гэсэн 4 цогцолбор
18. Эхийн гол санаанд тохирох хэлцийг ол.
 А. Үртэй хүн жаргадаг, үндэстэй мод ургадаг
 В. Хайр нь дотроо, хал нь гаднаа
 С. Хүүгийн алдар мандвал эхийн үрчлээ тэнийх
 Хүүгийн нэр сэвтвэл эхийн үрчлээ нэмэгдэх
 Д. Ухаантай хүн үгээрээ сургах, ууртай хүн нударгаараа сургах
 Е. Үрээ гэвэл сургаж бай, үрээгээ гэвэл идүүлж бай
19. Эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.
 А. Тоочимж
 В. Эргэцүүлэмж
 С. Хүүрнэмж
 Д. Тайлбарламж
 Е. Харьцууламж
20. Дээрх эхэд байгаа "хэчнээн" гэсэн үгийн төлөөлж буй утгыг ол.
 А. Бодит нэрийг
 В. Тоо ширхгийг
 С. Чанар шинжийг
 Д. Цаг хугацааг
 Е. Орон байрыг
21. "Үүнийг үзээд миний элэг эмтрэх шиг, зүрх зүсэгдэх шиг болов." гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг ол.
 А. Зүйрлэл
 В. Адилтгал
 С. Хэтрүүлэл
 Д. Төлөөлөл
 Е. Ёгтлол
22. Дээрх эхэд байгаа "миний" гэдэг үгийн язгуурыг ол.
 А. Миний
 В. Минь
 С. Ми
 Д. Би
 Е. Мин
23. Дээрх эх найруулгын ямар төрөлд багтах вэ?
 А. Уранзохиолын найруулга
 В. Сонины найруулга
 С. Шинжлэх ухааны найруулга
 Д. Албан бичгийн найруулга
 Е. Ярианы найруулга
24. "Ээж ээ, хүү чинь таныгаа баярлуулахаас илүү гомдоосон, хайрлахаасаа илүү зовоосон нь олон билээ" гэсэн өгүүлбэр дэх онцолсон үгс утгын ямар харьцаанд байна вэ?
 А. Ойролцоо утгын
 В. Эсрэг утгын
 С. Төсөө утгын
 Д. Зүйлчилсэн утгын
 Е. Өвөрмөц хэлцийн
25. "Та хүүгийнхээ төлөө хэчнээн өдөр шаналж, хэчнээн шөнө нойргүйтэж, нойтон нулимсаар дэрээ норгоо бол оо" гэсэн өгүүлбэрт тохирох шинжийг ол.
 А. ЗНӨ
 В. ЭДӨ
 С. УНӨ
 Д. ХаЗНӨ
 Е. ХоНӨ
26. Дээрх эхэд байгаа "...шөнө нойргүйтэж" гэсэн өгүүлбэрийн гишүүд ямар харьцаанд байна вэ?
 А. Өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн
 В. Шууд бус тусагдахуун, өгүүлэхүүн
 С. Байц, өгүүлэхүүн
 Д. Шууд тусагдахуун, өгүүлэхүүн
 Е. Тодотгол, байц
27. "Хэрэг төвөгт орооцолдсон шөнө миний нойр хулжиж, орондоо хөрвөөж, өөрийн хийсэн алдаагаа бодож хэвтгэл ижий минь мэгшин уйлах сонстов" гэсэн өгүүлбэрт тодотгол гишүүн өгүүлбэр хэд байна вэ?
 А. 4
 В. 2
 С. Байхгүй
 Д. 1
 Е. 3
28. "...намайг шийтгүүлж ял хүлээхэд..." хэмээх өгүүлбэр дэх "намайг" гэсэн үг ямар гишүүн болох вэ?
 А. Өгүүлэгдэхүүн
 В. Тодотгол
 С. Байц
 Д. Шууд бус тусагдахуун
 Е. Тусагдахуун
29. Дараах холбоо үгсийн аль нь утгажсан холбоо үг вэ?
 А. Хэрэг төвөг
 В. Санд мэнд
 С. Элэг эмтрэх
 Д. Зовж байх
 Е. Үр миний
30. Дараах холбоо үгсийн утга, бүтцийн дараалал, зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг ол.
 хэрэг төвөг, миний нойр, өр зүрх, хүүгийн бодол
 А. Санд мэнд
 В. Элэг эмтрэх
 С. Хийсэн алдаа
 Д. Эхийн сэтгэл
 Е. Зүрх зүсэгдэх
31. "Шагнуулж" гэсэн үгийг бүтцээр зөв задалсан хэсгийг ол.
 А. Шагна + уул + ж
 В. Шаг + нуул + ж
 С. Шаг + на + уул + ж
 Д. Шан + на + уул + ж
 Е. Шагна + уу + лж
32. "...Хэрэг төвөгт орооцолдсон шөнө миний нойр хулжиж, орондоо хөрвөөж, өөрийн хийсэн алдаагаа бодож хэвтгэл, ижий минь мэгшин уйлах сонстов. Санд мэнд босож очвол надаас нууж уйлсан ижий минь нулимс нүдийг нь бөлцийлгөж, хацрыг нь норгожээ" гэсэн цогцолборт үйл үг/давхардсан тоогоор/ хэд байна вэ?
 А. 10
 В. 14
 С. 12
 Д. 15
 Е. 13

33. “...ээж минь л юм” гэхэд илэрч буй баймж утгыг ол.
 А. Зайлшгүй баймж В. Бололцоот баймж
 С. Үнэн магадлалт баймж D. Тодорхой болох бодит баймж
 E. Салган онцолсон бодит баймж
34. Дараах холбоо үгсийн аль нь найрч угсарсан үйлийн холбоо үг вэ?
 А. Хэрэг төвөг В. Надаас нуух C. Нойр хулжих
 D. Ижий минь уйлах E. Санд мэнд босох
35. “Гэвч хүү нь эхийнхээ сэтгэлийг мэдэрсэн нь аз, хожуу ч гэсэн ухаарсан нь зол” гэсэн өгүүлбэр хэлэх зорилго, аялгаараа ямар өгүүлбэр вэ?
 А. Асуух өгүүлбэр В. Анхааруулах өгүүлбэр C. Хүүрнэх өгүүлбэр
 D. Захирах өгүүлбэр E. Батлах өгүүлбэр
36. “Монголын нууц товчоо” зохиолын эхлэл өгүүлбэрийн цэгийн оронд доорх хэсгүүдийн аль нь дарааллаараа тохирох вэ? “.....хааны язгуур, дээр тэнгэрээс заяат төрсөн, гэргий.....хамт тэнгис далайг гэтлэн ирээд Онон мөрний эхуулнаа нутаглаж, гэдэг нэгэн хөвгүүнийг төрүүлжээ.
 А. Бөртэчино, Чингис, Гуа – Маралын, Бурхан халдун, Батцагаан
 В. Чингис, Батцагаан, Гуа – Маралын, Бурхан халдун, Бөртэчино
 С. Чингис, Бөртэчино, Гуа – Маралын, Бурхан халдун, Батцагаан
 D. Бөртэчино, Гуа – Маралын, Батцагаан, Бурхан халдун, Чингис
 E. Чингис, Батцагаан, Бөртэчино, Гуа – Маралын, Бурхан халдун
37. “Үүр цайх” гэсэн холбоо үгийн “үүр” гэдэг үгийг зөв бичсэн хэсгийг ол.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

38. Зөөлөн дэвсгэрээр төгссөн хэсэг аль нь вэ?

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

39. Заахын тийн ялгалын нөхцөлийг зөв дагуулсан хэсгийг ол.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

40. Тодотгон холбохын “-сан/-сэн” нөхцөлийг зөв дагуулсан хэсэг аль нь вэ?

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| | | | | |

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Дараах үгсийн аймгуудыг тохирох үгтэй нь зөв харгалзуул. (5 оноо)
- | | |
|-----------------|-----------|
| А. Тэмдэг нэр | 1. Төлөө |
| В. Холбох үг | 2. Хэд |
| С. Үйл үг | 3. Хэрэм |
| Д. Жинхэнэ нэр | 4. Саарал |
| Е. Төлөөний нэр | 5. Ажээ |
- 2.2. Дараах хэлцүүдийг утгатай нь зөв харгалзуул. (6 оноо)
- | | |
|------------------------|-------------------------------|
| А. Элэг эмтрэх | 1. Шохоорхох, сонирхох |
| В. Элэг дэвтээх | 2. Ихэд шаналан зовох |
| С. Шар махтайгаа хатах | 3. Үлэмж өрөвдөх |
| Д. Хүй нэгтэй | 4. Төрлийн холбоотой |
| Е. Нүд хужирлах | 5. Шаналсан сэтгэлийг баясгах |
| Ғ. Гар татах | 6. Харамлах |
- 2.3. Дараах ойлголтуудыг тохирох нөхцөлтэй нь зөв харгалзуул. (5 оноо)
- | | |
|----------------------------|-----------|
| А. Зөвлөн захирах | 1. -сан |
| В. Өнгөрсөн цагаар төгсгөх | 2. -аа |
| С. Тодотгон холбох | 3. -магц |
| Д. Өгөх оршихын тийн ялгал | 4. -аарай |
| Е. Бэлтгэн холбох | 5. -лаа |
- 2.4. 1-р хэсэгт өгсөн “Ижийгээ гомдоож болохгүй” гэсэн эхтэй холбоо бүхий дараах өгөгдөл ба санааг зөв харгалзуул. (4 оноо)
- | | |
|--|------------------|
| А. Хэрэг төвөгт орооцолдож эхийгээ уйлуулсан | 1. Шинэ санаа |
| В. Эх хүн үргэлж үр хүүхдийнхээ төлөө нойроо хугаслан, санаа зовж байдаг | 2. Төрмөл санаа |
| С. Дээрх эхэд зохиогч эхийн сэтгэлийг хэрхэн мэдэрч хүлээж авсан тухай илэрхийлсэн | 3. Гол санаа |
| Д. Элгээ эмгэртэл, зүрхээ зүсэгдгэл ухаарч байгааг дүрсэлсэн | 4. Зорьсон санаа |

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “нутаг” гэсэн үгийн “у” авианд тохирох шинжийг ол.
- | | | |
|------------------|------------|-----------|
| А. Балархай | В. Уруулын | С. Эм сул |
| Д. Хэлний урдуур | Е. Уйтан | |
2. “ааруул” гэсэн үгэнд хэдэн авиа, хэдэн үсэг байна вэ?
- | | | |
|-------------------|-------------------|-------------------|
| А. 5 авиа, 6 үсэг | В. 6 авиа, 6 үсэг | С. 4 авиа, 6 үсэг |
| Д. 6 авиа, 4 үсэг | Е. 5 авиа, 5 үсэг | |
3. Алдаатай бичсэн үгийг ол.
- | | | |
|----------------|------------|------------|
| А. Буудаллалаа | В. Барилаа | С. Ажиллаа |
| Д. Уншлаа | Е. Сурлаа | |
4. Дараах үүсмэл үгсийн бүтэц, утгыг ажиглаад бусдаасаа ялгаатай үгийг ол.
- | | | |
|--------------|--------------|--------------|
| А. Хуруувчил | В. Түргэвчил | С. Хөнгөвчил |
| Д. Нарийвчил | Е. Бүдүүвчил | |
5. Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
- | | | |
|----------|----------|----------|
| А. Сэрэл | В. Санал | С. Төрөл |
| Д. Үзэл | Е. Хүрэл | |
6. Зөв бичсэн үгийг ол.
- | | | |
|----------|-----------|----------|
| А. Гарая | В. Хүргье | С. Хоноё |
| Д. Уншья | Е. Бичие | |
7. Зэрэгцүүлэн холбохын “-ж” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай бичигдэх вэ?
- | | | |
|---------|---------|---------|
| А. Барь | В. Холь | С. Хумь |
| Д. Тань | Е. Сахь | |

8. Дараах үгсийг уншаад, нэг төрлийн утгын айд хамаарах хэсгийг ол.
А. Арван зургаа, бариул, мод, гүйх
В. Эргэн тойрон, сайн, гал, зузаан
С. Халаалт, бичээс, тоосго, давхих
D. Улаан, гонзгой, саарал, өндөр
E. Тэгш, сар, ширээ, гаглах
9. “Галуу дуурайж, хэрээ хөлөө хөлдөөх” гэсэн хэлцтэй ойролцоо утгатай хэлц аль нь вэ?
А. Хүн хэлээрээ, мал хөлөөрөө
В. Ааг идсэн илжиг, адуу дагаж гүйнэ
С. Нөхрийн хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ
D. Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд
E. Урд хөл гишгэвэл, хойд хөл дагана
10. Дараах үгсийг уншаад, цэгийн оронд тохирох үгийг ол.
Тооно, унь, багана, хана,
- А. Бүслүүр
В. Дээвэр
C. Өрх
D. Зуух
E. Хаалга
11. Дараах холбоо үгсийг уншаад, “гар” гэсэн үг шууд утгаараа орсон хэсгийг ол.
А. Гараар оёх
В. Гар харах
C. Гар татах
D. Хүнд гар
E. Гараа гаргах
12. “Нүднээс гарах” гэсэн хэлцтэй эсрэг утгатай үгийг ол.
А. Ядрах
В. Таргалах
C. Сурах
D. Аялах
E. Хичээх
13. Ойролцоо болон эсрэг утгатай үг хоёулаа орсон хэсгийг ол.
А. Цувж явсан барснаас, цуглаж суусан шаазгай дээр
В. Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал
С. Илжиг таргалбал, эзнээ өшиглөх
D. Зэмлэх үгийн ил нь, магтах үгийн далд нь
E. Олзны үүдийг нээж, гарзны хаалгыг хаах
14. Дараах үгсийг уншаад, харь үгийг ол.
А. Үнэг
В. Тэмцээн
C. Ногоо
D. Бууз
E. Хөдөө
15. Дараах үгсийг уншаад, нутгийн аялгууны үгийг ол.
А. Ялман
В. Сэвгэр
C. Аранга
D. Түүчээ
E. Даага

Уншиж ойлгоод задлал хийх эх

Намар

Намар надад аймшигтай санагддаг. Гуниг нөмөрсөн хүмүүс. Бөгтийсөн гудамж. Надаас тасарсан навчис газраар нэг хөглөрч... Хөглөрөх навчис хүмүүсийн хөлд гишгэгдэхэд доромжлуулсан мэт санагддаг. Санаа алдахад минь салхи исгэрэх шиг жихүүцэл төрдөг. Намар надад аймшигтай санагддаг.





















Гинших навчсын чимээ гэртээ байхгүй эмээг минь санагдуулдаг. Харц минь шарлаж, хагдарч сэмэрсээр нүв нүцгэнээрээ хамгийн сүүлчийн бээрсэн шувуу цээжний гүнд үүрээ засдаг. Тэр шувуу надтай хамт даарч, тэр шувуу надтай хамт дуугаа хурааж, зөвхөн насны тухай, өвлийн тухай бодлогоширно. Намар надад эмгэнэлтэй санагддаг. Зүсэр бороо нь зүүгээр шивэх шиг зүсийг минь, арьсыг минь гэмтээж орхидог.

Удахгүй өвөл болно. Удахгүй үс минь цайна. Бүр цав цагаан болно. Удахгүй зүрх даарч, амьсгал цантаж эхэлнэ. Гар, хөл, нүд, уруул, бүгд цав цагаан болно. Хөмсөг ч ялгаагүй. Гишгэсэн мөр, инээд минь хүртэл цагаан болно. Удахгүй хүмүүс бүгдээрээ над шиг болно. Намар бидэнд юу бэлдсэнийг хараач.

(Х.Болор-Эрдэнэ)

16. Эхийн сэдэв аль нь вэ?
А. Намрын улирлын тухай
В. Намрын навчны тухай
С. Насны хяруу, өтөл насны тухай
D. Намрын уйтай өдрүүдийн тухай
E. Намар аймшигтай байдаг тухай
17. Эхийн найруулгын хэв маягийг тодорхойл.
А. Хүүрнэмж
В. Тайлбарламж
C. Тоочимж
D. Эргэцүүлэмж
E. Харьцууламж
18. Дээрх эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
А. “...аймшигтай санагддаг, ...гэмтээж орхидог, ...намар бидэнд юу бэлдсэнийг хараач” гэсэн 3 цогцолбор
В. “...аймшигтай санагддаг, ...эмгэнэлтэй санагддаг” гэсэн 2 цогцолбор
С. “...гэмтээж орхидог, ...намар бидэнд юу бэлдсэнийг хараач” гэсэн 2 цогцолбор
D. Бүхэлдээ 1 цогцолбор
E. “...аймшигтай санагддаг, ...намар бидэнд юу бэлдсэнийг хараач” гэсэн 2 цогцолбор

19. Эхийн гол санаанд тохирох хэлцийг ол.
 А. Уруудахад унтах идэх, өөдлөхөд санах сэрэх
 В. Уулыг цас дардаг, эрийг нас дардаг
 С. Цаасан дээр нэртэй, цасан дээр мөртэй
 D. Өвлийн тэнгэр цастай, үүрсэг хүн гийчтэй
 E. Мөнх настай, мөнгөн дөрөөтэй
20. Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
 А. Уран зохиолын найруулга
 В. Сонин найруулга
 С. Эрдэм шинжилгээний найруулга
 D. Албан бичгийн найруулга
 E. Ярианы найруулга
21. “...Гинших навчсын чимээ гэртээ байхгүй эмээг минь санагдуулдаг” гэсэн өгүүлбэрт ямар дүрслэх ур маяг /хэрэглүүр/ ашигласан байна вэ?
 А. Адилтгал
 В. Зүйрлэл
 С. Төлөөлөл
 D. Хүншүүлэл
 E. Хэтрүүлэл
22. Дараах дүрслэх ур маяг /хэрэглүүр/ бүхий нэгжүүдийн алинд нь зүйрлэл илэрч байна вэ?
 А. Гинших навч
 В. Шувуу бодлогоширч
 С. Зүсэр бороо зүүгээр шивэх шиг
 D. Шувуу цээжний гүнд үүрээ засдаг
 E. Зүрх даарч, амьсгал цантаж эхэлнэ
23. “Намар надад аймшигтай санагддаг. Гуниг нөмөрсөн хүмүүс. Бөгтийсөн гудамж. Надаас тасарсан навчис газраар нэг хөглөрч... Хөглөрөх навчис хүмүүсийн хөлд гишгэгдэхэд доромжлуулсан мэт санагддаг. Санаа алдахад минь салхи исгэрэх шиг жихүүцэл төрдөг. Намар надад аймшигтай санагддаг” гэсэн эхийн хэсэгт үйл үг давхардсан тоогоор хэд байна вэ?
 А. 18
 В. 13
 С. 12
 D. 14
 E. 17
24. Дээрх эхийн хэсэг /23-р сорил/-т ороогүй үгсийн аймгийг ол.
 А. Тооны нэр
 В. Орон цагийн нэр
 С. Үйл үг
 D. Чимэх үг
 E. Тэмдэг нэр
25. “Надад” гэсэн үгийн язгуур аль нь вэ?
 А. Над
 В. На
 С. Би
 D. Надад
 E. Миний
26. “Бэлдсэнийг” гэсэн үгийг зөв задалсан хэсгийг ол.
 А. Бэл + н + д + сэн + ийг
 В. Бэлэн + д + сэн + ийг
 С. Бэлд + сэн + ийг
 D. Бэл + д + сэн + ийг
 E. Бэлдсэн + ийг
27. Дараах үүсмэл үгсийг уншаад, 2 дагавар, 1 нөхцөл орсон үгийг ол.
 А. Бодлогоширно
 В. Доромжлуулсан
 С. Бэлдсэнийг
 D. Санагдуулдаг
 E. Амьсгал
28. Дараах холбоо үгсээс найрч угсарсан холбоо үгийг ол.
 А. Надад санагдах
 В. Жихүүцэл төрөх
 С. Зүсэр бороо
 D. Хамт бодлогошрох
 E. Цав цагаан
29. Бүгд нэг утгын зүйлчлэлд хамаарах хэсгийг ол.
 А. Надад, намар, хүмүүс, үс
 В. Навч, чимээ, нүд, уруул
 С. Хөл, үс, гудамж, мөр
 D. Дуу, хөмсөг, гэр, зүрх
 E. Гар, хөл, уруул, нүд
30. “...Гуниг нөмөрсөн хүмүүс” гэдэг өгүүлбэрт “гуниг” гэсэн үг ямар гишүүн болох вэ?
 А. Өгүүлэгдэхүүн
 В. Байц
 С. Шууд тусагдахуун
 D. Тодотгол
 E. Шууд бус тусагдахуун
31. “...Гуниг нөмөрсөн хүмүүс” гэсэн өгүүлбэрт тохирох шинжийг ол.
 А. ЗНӨ
 В. 1 бүрэлдэхүүнт өгүүлбэр
 С. 2 бүрэлдэхүүнт өгүүлбэр
 D. 3 бүрэлдэхүүнт өгүүлбэр
 E. хураангуй өгүүлбэр
32. Дараах холбоо үгсээс бүхэлзүйжсэн холбоо үгийг ол.
 А. Өвөл болох
 В. Цав цагаан
 С. Хүмүүс бүгдээрээ
 D. Санаа алдах
 E. Цантаж эхлэх
33. Дараах өгүүлбэрүүдээс “Тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр”-ийг ол.
 А. Намар надад аймшигтай санагддаг
 В. Зүсэр бороо нь зүүгээр шивэх шиг зүсийг минь арьсыг минь гэмтээж орхидог
 С. Намар бидэнд юу бэлдсэнийг хараач
 D. Тэр шувуу надтай хамт даарч, тэр шувуу надтай хамт дуугаа хурааж, зөвхөн насны тухай, өвлийн тухай бодлогоширно
 E. Гинших навчсын чимээ гэрт байхгүй эмээг минь санагдуулна

34. "...Намар бидэнд юу бэлдсэнийг хараач." гэсэн өгүүлбэр хэлэх зорилго, аялгын хувьд ямар өгүүлбэр вэ?
 А. Асуух өгүүлбэр В. Анхааруулах өгүүлбэр С. Хүүрнэх өгүүлбэр
 D. Захирах өгүүлбэр E. Батлах өгүүлбэр
35. "Санаа алдах" гэсэн өвөрмөц хэлцтэй ойролцоо утгатай хэлцийг ол.
 А. Нойр алдах В. Ам алдах С. Шүүрс алдах
 D. Нүд алдах E. Ухаан алдах
36. "Монголын нууц товчоо" зохиолын 96-р зүйлийн орхигдсон/Ван ханаас Тэмүжинд хандаж хэлсэн/ үгсийг нөхөхөд аль хэсэг нь дарааллаараа тохирохыг ол.
 "..... чинь хариуд
 Хагацсан улсыг чиньөгье.
чинь хариуд
 Бутарсан улсыг чиньөгье.
цээжинд байг
бөгсөнд байг"
- А. Булган дахны, цуглуулж, хамтатгаж, хар булган дахны, бөөр нь, цэр нь
 В. Хар булган дахны, хамтатгаж, булган дахны, цуглуулж, бөөр нь, цэр нь
 С. Булган дахны, хамтатгаж, хар булган дахны, цуглуулж, цэр нь, бөөр нь
 D. Булган дахны, цуглуулж, хар булган дахны, хамтатгаж, цэр нь, бөөр нь
 E. Хар булган дахны, хамтатгаж, булган дахны, цуглуулж, цэр нь, бөөр нь
37. "Хор шар" гэсэн холбоо үгийн "хор" гэдэг үгийг зөв бичсэн хэсэг аль нь вэ?
 А.  В.  С.  D.  E. 
38. Хатуу дэвсгэрээр төгссөн үгстэй хэсгийг ол.
 А.  В.  С.  D.  E. 
39. Харьяалахын тийн ялгалын нөхцөлийг зөв дагуулсан хэсэг аль нь вэ?
 А.  В.  С.  D.  E. 
40. Цагаар төгсгөх "-жээ/-чээ" нөхцөлийг зөв дагуулсан хэсгийг ол.
 А.  В.  С.  D.  E. 

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. 1-р хэсэгт өгсөн "Намар" гэсэн эхтэй холбогдол бүхий дараах өгөгдөл ба санааг зөв харгалзуул. (4 оноо)
- | | |
|--|------------------|
| А. Намрын улирлын уйтай байдал | 1. Шинэ санаа |
| В. Санааг илэрхийлэхдээ дүрслэх ур маягийг чадмаг ашигласан | 2. Төрмөл санаа |
| С. Намрын бодит байдлыг танин мэдэж, өөрийн үнэлэмж дүгнэлтээр хандсан | 3. Гол санаа |
| D. Насны хяруу, өтөл нас хаяанд ирсэн | 4. Зорьсон санаа |

- 2.2. Дараах үгсийн аймгуудыг тохирох үгтэй нь зөв харгалзуул. (5 оноо)
- | | |
|--------------------|------------|
| А. Холбох үг | 1. Гадна |
| В. Орон цагийн нэр | 2. Хага |
| С. Тэмдэг нэр | 3. Эсвэл |
| Д. Чимэх үг | 4. Ямар |
| Е. Төлөөний нэр | 5. Гонзгой |
- 2.3. Дараах зохиолчдыг бүтээлтэй нь зөв харгалзуул. (6 оноо)
- | | |
|------------------|-----------------------|
| А. Б.Лхагвасүрэн | 1. Их тэнгэрийн дүлий |
| В. Д.Нацагдорж | 2. Цахилж яваа гөрөөс |
| С. С.Буяннэмэх | 3. Ээж ээ |
| Д. Ц.Дамдинсүрэн | 4. Боржигоны бор тал |
| Е. Д.Батбаяр | 5. Дөрвөн цаг |
| Ф. Л.Ванган | 6. Чөтгөр |
- 2.4. Дараах ойлголтуудыг тохирох нөхцөлтэй нь зөв харгалзуул (5 оноо)
- | | |
|----------------------------|----------|
| А. Хүндэтгэн захирах | 1. -сан |
| В. Ирээдүй цагаар төгсгөх | 2. -д |
| С. Тодотгон холбох | 3. -вч |
| Д. Өгөх оршихын тийн ялгал | 4. -гтун |
| Е. Дутагдан холбох | 5. -на |

2007 оны Монгол хэлний хичээлийн даалгаврын түлхүүр

Нэгдүгээр хэсэг			
№	А хувилбар	В хувилбар	С хувилбар
1	D	E	B
2	B	A	C
3	D	B	C
4	C	E	A
5	B	A	B
6	E	C	C
7	A	D	E
8	D	D	D
9	B	A	B
10	C	C	E
11	B	E	A
12	A	C	B
13	B	A	E
14	C	C	D
15	A	B	B
16	B	C	C
17	D	A	D
18	D	C	A
19	A	B	B
20	E	B	A
21	B	D	D
22	C	D	C
23	E	A	B
24	C	A	B
25	B	B	C
26	B	C	B
27	B	B	A
28	A	A	A
29	B	C	E
30	A	A	C
31	B	D	D
32	D	D	C
33	A	E	E
34	D	B	B
35	D	C	C
36	A	C	E
37	C	D	B
38	A	E	D
39	E	D	E
40	C	A	B

Хоёрдугаар хэсэг											
А хувилбар				В хувилбар				С хувилбар			
2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4
5	2	3	1	4	3	4	2	2	3	4	4
1	4	5	3	1	5	5	3	1	1	5	5
2	1	4	4	5	2	1	4	4	5	1	1
3	5	1	2	3	4	2	1	3	2	6	2
4	3	2		2	1	3			4	2	3
	6				6					3	

